



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 123

Улаанбаатар хот

Ном акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.3, 6.2.5, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хүүхдийн төв номын сангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, утга агуулгаар хуучирсан, сэлбэж засах боломжгүй, элэгдэж гэмтсэний улмаас хэрэгцээ хангахгүй болсон, нийт 44,309,082.00 (дөчин дөрвөн сая гурван зуун есөн мянга наян хоёр) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан номыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэн, Хүүхдийн төв номын сангийн захирал Д.Оюунбилэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, ашиглаж болох номыг үнэ хямдруулан буюу хоёрдогч түүхий эд хүлээн авах байгууллагад зохих үнээр нь худалдах, түүх, соёлын хэрэгцээ шаардлагыг харгалзан 1-3 ширхэгийг үлдээх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001601

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн
 128 дугаар тогтоолын хавсралт



Хүүхдийн төв номын сангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
 акталж, данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын		
				нэг бүрийн үнэ	нийт үнэ	Үлдэгдэл өртөг
1	Ном (орос)	ш	7678	15,890,960.0	15,890,960.0	15,890,960.0
2	Ном (англи)	ш	2500	24,225,062.0	24,225,062.0	24,225,062.0
3	Ном (тогтмол хэвлэл)	ш	20	3,967,400.0	3,967,400.0	3,967,400.0
4	Ном (тогтмол хэвлэл)	ш	19	79,860.0	79,860.0	79,860.0
5	Хуурцаг (CD)	ш	17	145,800.0	145,800.0	145,800.0
Нийт дүн			10,234		44,309,082.00	44,309,082.00
				(дөчин дөрвөн сая гурван зуун есөн мянга наян хоёр)		